

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/06/НА-СТА-ТӨА

ЭРДЭНЭСАНТ АЗЗА ТӨХК-НИЙ 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amariargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай Аудит” ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	17
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	17
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.16 № 01/214
танай _____ -ны № _____ -т

**ЭРДЭНЭСАНТ АЗЗА ТӨХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.БАЯСГАЛАН ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жилийн эцсийн тооллогоор 36,228.3 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг биетээр гүйцэтгээгүй, тайлант оны 10, 11, 12 дугаар саруудад 178,153.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг харилцагч байгууллагын нэхэмжлэх болон бусад холбогдох анхан шатны баримтын бүрдэл хангаагүй гүйцэтгэсэн зэрэг зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/, мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр удирдлагын зардал 131,809.6 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд байгууллагын хэвийн ажиллагааг хангах зорилгоор хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 271,315.0 мянган төгрөгийн зээл авсныг тайлант ондоо төлж барагдуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тайлант онд гүйцэтгэлээр 1,045,929.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,308,594.6 мянган төгрөгийн зардал гарган, 262,665.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	38,004,163.26	8,179,614.05
1.1.2	Дансны авлага	19,085,932.00	28,265,536.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	13,920,853.37	19,308,425.67
1.1.4	Бусад авлага	5,510,189.44	7,900,000.00
1.1.6	Бараа материал	25,656,186.28	36,228,299.14
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	102,177,324.35	99,881,874.86
1.2.1	Үндсэн хөрөнгө	598,934,026.42	531,138,510.31
1.2.2	Биет бус хөрөнгө	40,619,708.33	40,615,369.44
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	639,553,734.75	571,753,879.75
1.3	Нийт хөрөнгийн дүн	741,731,059.10	671,635,754.61
2.1.1.1	Дансны өглөг	184,221,899.85	332,736,672.34
2.1.1.2	Цалингийн өглөг	-	21,132,852.42
2.1.1.3	Татварын өр	39,454,054.26	76,538,073.07
2.1.1.4	НДШ - ийн өглөг	109,483,155.59	97,427,858.31
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	19,685,611.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	333,159,109.70	547,521,067.14
2.2	Өр төлбөрийн нийт дүн	333,159,109.70	547,521,067.14
2.3	Өмч	1,018,908,828.41	1,018,908,828.41
2.3.1	- төрийн	1,018,908,828.41	1,018,908,828.41
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25,244,498.98	25,244,498.98
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	40,270,000.00	40,270,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(675,851,377.99)	(960,308,639.92)
2.3.11	Эздийн өмчийн дүн	408,571,949.40	124,114,687.47
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	741,731,059.10	671,635,754.61

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	942,896,172.73	972,030,269.91
2	Борлуулалтын өртөг	988,814,400.06	1,029,127,781.78
3	Нийт ашиг (алдагдал)	(45,918,227.33)	(57,097,511.87)
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	8,181,818.18	52,107,090.91
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	239,761,082.73	267,391,280.97
11	Санхүүгийн зардал	1,528,335.00	6,382,500.00
12	Бусад зардал	13,715,774.49	5,693,060.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(292,741,601.37)	(284,457,261.93)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(292,741,601.37)	(284,457,261.93)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(292,741,601.37)	(284,457,261.93)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(292,741,601.37)	(284,457,261.93)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-ны үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(358,275,341.20)	726,147,986.19
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-		-	-
3	Залруулсан үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(358,275,341.20)	726,147,986.19
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(292,741,601.37)	(292,741,601.37)
5	Бусад дэлгэрэнгүй орлого		-	-		-
6	Өмчид гарсан өөрчлөлт		-	-		-
7	Зарласан ногдол ашиг		-		-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				(24,834,435.42)	(24,834,435.42)
9	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(675,851,377.99)	408,571,949.40
10	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл				-	-
11	Залруулсан үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(675,851,377.99)	408,571,949.40
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(284,457,261.93)	(284,457,261.93)
13	Бусад дэлгэрэнгүй орлого		-	-		-
14	Өмчид гарсан өөрчлөлт			-		-
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-			-
17	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,018,908,828.41	25,244,498.98	40,270,000.00	(960,308,639.92)	124,114,687.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	1,047,904,486.00	1,135,194,958.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,047,628,813.00	477,573,635.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	255,673.00	46,777.65
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	622,830,145.35
1.1.6	Бусад мөнгөн орлого	20,000.00	34,744,400.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	1,041,631,626.66	1,192,213,607.21
1.2.1	Ажиллагчдад төлсөн	410,118,460.76	396,748,422.77
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	58,161,678.44	149,988,669.93
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	238,177,035.83	462,988,715.25
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,845,219.23	1,514,981.18
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	129,325,340.00	45,516,489.58
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	1,528,335.00	2,812,500.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	135,874,908.71	73,457,443.68
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	857,025.00	886,875.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	65,743,623.69	58,299,509.82
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,272,859.34	(57,018,649.21)
2.1	Мөнгөн орлогын дүн	1,950,000.00	34,070,000.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,950,000.00	30,500,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		3,570,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	4,081,600.00	7,875,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,081,600.00	7,875,900.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,131,600.00)	26,194,100.00
3.1	Мөнгөн орлогын дүн	31,000,000.00	271,315,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	31,000,000.00	271,315,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	31,000,000.00	270,315,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	31,000,000.00	270,315,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	1,000,000.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,141,259.34	(29,824,549.21)
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	33,862,903.92	38,004,163.26
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	38,004,163.26	8,179,614.05

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<u>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</u>		<u>951,078.0</u>	<u>2,016,272.7</u>	<u>1,045,929.5</u>	970,343.2	51.9
	Улсын чанартай зам засварын ажил	мян.төг	942,896.2	1,834,454.5	976,929.5	857,525.0	53.3
	Орон нутгийн чанартай зам засварын ажил	мян.төг	8,181.8	181,818.2	69,000.0	112,818.2	37.9
2	Нийт орлого	мян.төг	951,078.0	2,016,272.7	1,045,929.5	970,343.2	51.9
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	951,078.0	2,016,272.7	1,045,929.5	970,343.2	51.9
3	Нийт зардал	мян.төг	1,213,819.6	2,005,372.9	1,308,594.6	696,778.3	65.3
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	239,761.1	387,080.4	255,270.8	131,809.6	65.9
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	(262,741.6)	10,899.8	(262,665.1)	273,564.9	(2,409.8)
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	-	9,809.8	-	9,809.8	-
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	223,695.3	340,606.0	212,665.4	127,940.6	62.4
	а/ Орлогын татварт	мян.төг	11,823.6	1,090.0	-	1,090.0	-
	б/ НӨАТ	мян.төг	96,243.7	140,489.0	40,680.7	99,808.3	29.0
	в/ НДШ	мян.төг	58,161.7	152,301.5	149,988.7	2,312.8	98.5
	г/ Хүн амын орлогын албан татвар	мян.төг	46,036.7	42,057.5	18,075.4	23,982.1	43.0
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	2,012.6	2,918.0	2,616.7	301.3	89.7
	е/ Гаалийн татвар	мян.төг	-	-	-	-	-
	ж/ Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	1,067.8	1,200.0	1,029.7	170.3	85.8
	з/ Бусад татварт	мян.төг	8,349.2	550.0	274.2	275.8	49.9
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	-	2,192.7	-	2,192.7	-
8	Нийт ажиллагсдын тоо	Хүн	39.0	41.0	37.0	4.0	90.2
9	Нийт цалингийн сан	мян.төг	522,884.3	516,076.4	539,641.5	(23,565.1)	104.6
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.28	0.99	1.25	(0.26)	126.3
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	-	48,000.0	-	48,000.0	-
12	Нийт авлага	мян.төг	38,517.0	19,085.0	25,085.9	(6,000.9)	131.4
13	Нийт өглөг	мян.төг	333,159.1	125,000.0	546,650.7	(421,650.7)	437.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь эрхэм зорилгоо “Төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг хариуцсан замын хэмжээнд зохион байгуулж, түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн 4 улирлын туршид бүрэн хангах” гэж тодорхойлсон.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний дүрэм, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт
- Хатуу хучилттай авто зам барих
- Хайрган хучилттай авто зам барих
- Бүх төрлийн гүүр, туннель, газар доогуур нүхэн гармын арчлалт, урсгал засвар, ээлжит засварын ажил

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани статустай байна. Төрийн өмчийн хорооны 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 437 дугаар тогтоолоор Улаанбаатар АЗЗА ТӨХК-аас тусгаарлан байгуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь Монгол Улсын Төрийн өмчийн хорооны 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 437 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах...” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тогтоол “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тус байгууллагын 2021 оны удирдлага, санхүү аж ахуй, эдийн засгийн үйл ажиллагаанд, Төв аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албаны 2022 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө, аймгийн Засаг дарга бөгөөд дотоод аудитын хорооны даргын баталсан 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 33/50 дугаар удирдамжийн дагуу 2020, 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд тус тус дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ий 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ий 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70,095.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	38,004.1	8,179.6	(29,824.5)
Авлага	38,517.0	55,473.9	16,956.9
Бараа материал	25,656.2	36,228.3	10,572.1
Үндсэн хөрөнгө	598,934.0	531,138.5	(67,795.5)
Биет хөрөнгө	40,619.7	40,615.4	(4.3)
Нийт хөрөнгө	741,731.0	671,635.7	(70,095.3)
Богино хугацаат өр төлбөр	333,159.1	547,521.0	214,361.9
Урт хугацаат өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,018,908.8	1,018,908.8	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25,244.5	25,244.5	-
Эздийн өмчийн бусад хэсэг	40,270.0	40,270.0	-
Хуримтлагдсан ашиг	(675,851.4)	(960,308.6)	(284,457.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	741,731.0	671,635.7	(70,095.3)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн данснуудад байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 8,179.6 мянган төгрөг болж 29,824.5 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант оны эцэст касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлгүй, харилцах дансны 8,179.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 16,956.9 мянган төгрөгөөр өссөн нь дотоод хяналтаар ажиллагсадтай холбоотой төлбөрийн акт тогтоож, ажиллагсдаас авах авлага нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,572.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст түүхий эд материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 67,795.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд төлөгдөх хугацаандаа байгаа байгууллагад төлөх өглөг 332,736.7 мянган төгрөг, цалингийн өглөг 21,132.9 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 97,427.9 мянган төгрөг, татварын өглөг 76,538.1 мянган төгрөг, урьдчилж орсон орлого 19,685.6 мянган төгрөг, нийт 547,521.1 мянган төгрөгийн өр төлбөрийг тусган тайлагнасан байна.

Тайлант онд байгууллагын хэвийн ажиллагааг хангах зорилгоор хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 271,315.0 мянган төгрөгийн зээл авсныг тайлант ондоо төлж барагдуулсан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 661 дугаар тогтоолоор Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ний 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 2,016,272.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,005,372.9 мянган төгрөгөөр, 10,899.8 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 48,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,045,929.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,308,594.6 мянган төгрөгийн зардал гарган, 262,665.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,045,929.5 мянган төгрөг болж төлөвлөснөөс 970,343.2 мянган төгрөг буюу 51,9 хувиар тасарсан нь улсын болон орон нутгийн чанартай зам засварын ажлын санхүүжилт буурснаас голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,308,594.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 696,778.3 мянган төгрөг буюу 65.3 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь улсын болон орон нутгийн чанартай зам засварын ажлын санхүүжилт буурч, холбогдох зардал буурснаас гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 262,665.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 273,564.9 мянган төгрөгөөр илүү байгаа нь зам засварын ажлын түүхий эд материал, шатахууны үнэ өссөнөөс шалтгаалж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ий 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй, тайлагнахгүй байхтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин, С.Батжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ий 2022 оны санхүүгийн тайлангаа “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан зорилтот түвшний нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны зорилтот түвшний гүйцэтгэлийн тайланг, суурь үзүүлэлтийг батлагдсан зорилтот түвшний нийт зардал 2,005,372.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 30,080.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 22,560.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр удирдлагын зардал 131,809.6 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 191 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 191 мэдээллээс 161 мэдээллийг хугацаандаа, 29 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь 2022 оны "Худалдан авах ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө"-өөр нийт 661,163.0 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөснөөс нээлттэй тендер шалгаруулалтаар 541,728.0 мянган төгрөг, шууд худалдан авалтаар 119,435.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөсөн байна.

Нээлттэй тендер шалгаруулалтаар нийт 2 худалдан авалтыг гүйцэтгэж, шууд худалдан авалтаар 3 худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан ажилласан байна.

Тайлант онд нийт 661,163.0 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 310,219.5 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээ байгуулан ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ий 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 455,552.6 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс 1,247.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 89,179.3 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 365,126.1 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөн байна. Үүнээс тайлант онд 89,179.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 365,126.1 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, 1,247.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулаагүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарч байна. Хэрэгжилт 77.5 хувьтай.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Б	1	2	3	4	5	6
1	Акт	1	1,247.2	-	-	0.0
2	Албан шаардлага	4	89,179.3	3	89,179.3	75.0
3	Зөвлөмж	4	365,126.1	4	365,126.1	100.0
	Нийт дүн	9	455,552.6	7	454,305.4	77.5

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрдэнэсант АЗЗА ТӨХК нь байгууллагын хэвийн ажиллагааг хангах зорилгоор хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагатай зээлийн гэрээ байгуулан нийт 271,315.0 мянган төгрөгийн зээл авч, тайлант онд бүрэн барагдуулсан байна. Зээлийн гэрээ байгуулан, зээл олгож байгаа хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага нь байгууллагын удирдлагатай хамаарал бүхий этгээд байгаа нь анхаарал татахуйц байна. Тиймээс дараагийн аудитаар байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагаас авсан зээлийн зарцуулалтад нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 469,124.2 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс 45,490.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 245,479.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага хүргүүлж, 178,153.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Аудитын явцад 45,490.4 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэнийг залруулсан.
2. Санхүүгийн тайлангийн Орлого үр дүнгийн тайланг Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайлантай тулгахад татварын тайланг 4,899.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.
3. Санхүүгийн тайлангийн Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг 40,591.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 245,479.9 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Жилийн эцсийн тооллогын комиссыг Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/01 дүгээр "Тооллогын комисс томилох тухай" тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг 2023 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөр тасалбар болгон, тайлант ондоо багтаан гүйцэтгээгүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1-д "Үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Тасалбар болголт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/01 дүгээр "Тооллогын комисс томилох тухай" тушаалаар жилийн эцсийн тооллогын комиссыг 6 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг 2023 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хооронд гүйцэтгэхдээ 36,228.3 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг биетээр гүйцэтгээгүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бараа материалын тооллогыг гүйцэтгэж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд дансны өглөг 148,514.8 мянган төгрөгөөр, цалингийн өглөг 21,132.9 мянган төгрөгөөр, татварын өглөг 37,084.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн төсвийн хөрөнгийг хэмнэлттэй байхаар зарцуулж, холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант онд хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагаас зээл авч, зээлийн хүү 2,520.0 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй зардлыг үйл ажиллагааны зардлаас төлсөн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн төлөвлөгдөөгүй зардал гаргахгүй байх, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацааны ажил гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад 10, 11, 12 дугаар саруудад 178,153.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг харилцагч байгууллагын нэхэмжлэх болон бусад холбогдох анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээг гүйцэтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй, тайлагнахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэнийг	1	-			1	-	1	-				
2	Санхүүгийн тайлангийн Орлого үр дүнгийн тайланг Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайлантай тулгахад татварын тайланг 4,899.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг	1	4,899.2			1	4,899.2	1	4,899.2				
3	Санхүүгийн тайлангийн Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг 40,591.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг	1	40,591.2			1	40,591.2	1	40,591.2				
	Дүн	3	45,490.4			3	45,490.4	3	45,490.4				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Жилийн эцсийн тооллогын комиссыг Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/01 дүгээр "Тооллогын комисс томилох тухай" тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг 2023 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 16-ны хооронд гүйцэтгэсэн	1	-			1	-						
2	Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/01 дүгээр "Тооллогын комисс томилох тухай" тушаалаар жилийн эцсийн тооллогын комиссыг 6 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тооллогыг 2023 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хооронд гүйцэтгэхдээ	1	36,228.3			1	36,228.3						

**Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан**

	36,228.3 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг биетээр гүйцэтгээгүй												
3	Тайлант онд дансны өглөг 148,514.8 мянган төгрөгөөр, цалингийн өглөг 21,132.9 мянган төгрөгөөр, татварын өглөг 37,084.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн	1	206,731.6			1	206,731.6						
4	Тайлант онд хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагаас зээл авч, зээлийн хүү 2,520.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардлаас төлж, төлөвлөгдөөгүй зардал гаргасан	1	2,520.0			1	2,520.0						
5	Тайлант хугацааны ажил гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгахад 10, 11, 12 дугаар саруудад 178,153.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг харилцагч байгууллагын нэхэмжлэх болон бусад холбогдох анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээг гүйцэтгэсэн	1	178,153.9					1	178,153.9				
	Дүн	5	423,633.8	-	-	4	245,479.9	1	178,153.9	-	-	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансанд мэдээлбэл зохих 191 мэдээллээс 161 мэдээллийг хугацаандаа, 29 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй байна.	1	-					1	-
	Дүн	1	-					1	

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn